



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 274

Улаанбаатар хот

“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын  
гэрээний стандарт загвар”-г нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 332 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний стандарт загвар”-ын 2, 6, 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалтыг тус тус нэмсүгэй:

1.1. загварын 2 дугаар зүйлд 2.1.8, 2.1.9 дэх заалт:

"2.1.8. “Жолоочийн даатгалын мэдээллийн сангаас олгож буй 14 орон бүхий дугаар даатгалын гэрээний баталгаа болно”,

2.1.9. “Жолоочийн даатгалын мэдээллийн сан гэж Жолоочийн даатгалын тухай хуулийн 24.1-д заасан санг”,

1.2. загварын 6 дугаар зүйлд 6.5 дахь хэсэг:

"6.5. “Суурь хураамжаас итгэлцүүрээр тооцсон даатгалын хураамж, даатгалын баталгаа /гэрээ/-ны хуулбарыг даатгуулагчийн хүсэлтээр дахин олгох зардлаас бусад аливаа хэлбэрээр шимтгэл, үйлчилгээний хөлс авахыг хориглоно”,

1.3. загварын 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт 8.2.7 дахь заалт:

"8.2.7. “Даатгалын гэрээний мэдүүлгийн маягтны мэдээлэл, нөхөн төлбөр, даатгалын тохиолдол, даатгуулагчийн талаарх мэдээллийн нэмэлт, өөрчлөлт зэргийг жолоочийн мэдээллийн санд тухай бүр үнэн зөв оруулах”.

2. Загварын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн "даатгалын үнэлгээний хэмжээ" гэсний дараа "даатгалын суурь хураамж" гэж, мөн хэсгийн "Жолоочийн даатгалын тухай хуулийн 9.1" гэсний дараа "10.1." гэж, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн "буцааж олгоно." гэсний дараа "Даатгалын гэрээ хүчинтэй байх хугацаанд даатгагч хохирлын нөхөн төлбөр олгосон нөхцөлд даатгалын хураамжийн буцаалт хийгдэхгүй." гэсэн үг, өгүүлбэр нэмсүгэй.

3. “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний стандарт загварын 4 дүгээр зүйлийн “4.1.1, 4.1.2, 4.1.3 дахь заалтын “хэрэгслээр” гэснийг “...хэрэгсэл жолоодож” гэж,

000370

6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн "дор дурдсан " гэснийг "5.1-д заасан" гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтын "даатгалын баталгааг" гэснийг "даатгалын баталгаа, гэрээг" гэж тус тус өөрчилсүгэй.

Загварын 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн 3 дугаар баганын “Даатгалын үнэлгээ” гэсний дараа “...буюу нэг удаа олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ” гэсэн өгүүлбэр, мөн “Даатгалын суурь хураамж” гэсэн багана нэмсүгэй.


№	Тээврийн хэрэгслийн ангилал	Даатгалын үнэлгээ буюу нэг удаа олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ /төгрөг/	Даатгалын суурь хураамж /төгрөг/	Үнэлгээ, ангиллыг тэмдэглэх +/-
1	“А” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая төгрөг хүртэл	12500	
2	“В” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая төгрөг хүртэл	33000	
3	“С” ангиллын тээврийн хэрэгсэл	10 сая төгрөг хүртэл	42500	
4	“D” ангиллын тээврийн хэрэгсэл	10 сая төгрөг хүртэл	53000	
5	“Механизм” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая төгрөг хүртэл	12500	

4.Гэрээний стандарт загварын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “тээврийн хэрэгслийн ангилал, даатгалын суурь хураамж, даатгуулсан ангиллыг тэмдэглэх гэсэн хүснэгт”, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг тус тус хассугай.

5.“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний стандарт загвар”-т орсон энэхүү нэмэлт, өөрчлөлтийг 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

6.Нэмэлт, өөрчлөлтийг “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний стандарт загвар”-т тусгаж олон нийтэд мэдээлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА